

“АТАР-ӨРГӨӨ” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 28

№01

Улаанбаатар хот

Хурлын цаг: 09:00-12:00

Хурлын байршил: “Атар-Өргөө” ХК-ны хурлын танхим

Хурлын дарга: Б.Мөнхдалай

Хурлын нарийн бичиг: С.Баярмаа

Хуралд оролцсон гишүүд: “Атар-Өргөө” ХК-ний хувьцаа эзэмшигч Бэрэн групп ХХКийг төлөөлж Б. Мөнхдалай, хувьцаа эзэмшигч Б.Ганбат /мөн хувьцаа эзэмшигч Н.Паламдоржийг итгэмжлэлээр төлөөлсөн /Г.Баттулга /мөн хувьцаа эзэмшигч Г.Энхболдыг итгэмжлэлээр төлөөлсөн/, “Таван богд инвестмент” ХХК-ийг төлөөлж өмгөөлөгч Н. Ариунболд, “Стандарт инвестмент” ХХК, хувьцаа эзэмшигч З.Төрболд, Д.Мөнхтуяа, Г.Үйтүмэн, С.Отгонсүрэн нар, Ж.Энхрийлэнг төлөөлж Жавхлан, иргэн С. Адьяабазарыг төлөөлж өмгөөлөгч Ц. Алтанцэцэг, иргэн О. Баттулгыг төлөөлж иргэн О. Баярсайхан нар оролцов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд П. Болормаа, Т. Жигмэддагва, С. Бямбахорлоо.

Тооллогын комиссын гишүүд: Ө. Оюун-Эрдэнэ, Н.Номин-Эрдэнэ, О.Даваажаргал нар.

Хурлын ирцийг тооллогын комисс бүртгэхэд 2023 оны 04 сарын 28-ны өдрийн ээлжит хуралд 174,136 ширхэг буюу 1,567,224 саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшдэг 364 хувьцаа эзэмшигч оролцохоос 95,502 ширхэг буюу 859,918 саналын эрхтэй 9 хувьцаа эзэмшигчид, 624,816 буюу 2 саналын эрхгүй хувьцаа эзэмшигч /О. Баттулга, С. Адьяабазар/ өөрөө буюу итгэмжлэлээр оролцож, хурлын ирц 54,84% хувь болсон Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх, Компанийн дүрмийн “Долоо”-ийн 7.4 дахь заалт болон 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 001/ХТ2022/01275 тогтоолыг тус тус үндэслэн, хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөр болсныг Тооллогын комиссын дарга, Ө.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Хурлыг нээж, хурлын дарга, Б.Мөнхдалай хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийг танилцуулж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1."Атар-Өргөө" ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулж батлах.

2."Атар-Өргөө" ХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн Аудитын байгууллагын дүгнэлтийг батлах.

3. Ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэн батлах.

4. "Атар-Өргөө" ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг батлах.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож, гишүүдийн цалингийн хэмжээ, дотоод ажлын тасвийг батлах.

6. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу хувьцааны хяналтын багцыг худалдахаар санал болгосон хувьцаа эзэмшигчдийн асуудлаар тусгайлан шийдвэр гаргах асуудлыг хэлэлцүүлж шийдвэр гаргах

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

ТУЗ-ийн дарга Б. Мөнхдалай танилцуулав.

1. Атар-Өргөө ХК нь 2022 онд дараах гол гол үйл ажиллагаануудыг ажилласан байна.
 - Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд шинээр цогц программ хангамж нэвтрүүлсэн
 - Борлуулалтын нэгдсэн түгээлтийн системийг бий болгох
 - Ажилчдын цалин хөлсний системийг гүйцэтгэл үр дүнд суурилсан системээр сайжруулах

Дээрх зорилтынхоо хүрээнд хэдийгээр ковидын дараах эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлтэй, түүхий эдийн үнэ нэмэгдсэн, тасарсан байдалтай байсан ч бүрэн хүчин чадлаа дайчлан ажиллаж борлуулалтын орлогыг 15,7 тэрбум төгрөг хүргэж, 469,8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Энэ талаар нарийвчилсан задаргаа, санхүүгийн тайлангийн баримтууд хувьцаа эзэмшигчдэд тараагдсан байгааг та бүхэн танилцсан байх гэж бодож байна.

Иймээс Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх удирдлагын багийг сайн ажилласан гэж дүгнээд, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг зөвшөөрч байна.

2. Атар-Өргөө ХК-ний 2022 оны санхүүгийн тайланд аудит хийсэн Мүүрь Аудит ХХК-ний дүгнэлт болон Аудитын хорооны дүгнэлтийг **Атар-Өргөө ХК-ний Аудитын хорооны**

дарга С. Бямбахорлоо танилцуулав. /Дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдэд хавсралт материалаар тарааж өгөв./

3. Ногдол ашиг хуваарилахгүй болсон талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 15-ны 01/23 тогтоолыг ТУЗ-ийн дарга Б. Мөнхдалай уншиж танилцуулав.

Атар-Өргөө ХК нь хэдийгээр 2022 онд 469,8 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч татварын хуримтлагдсан өр төлбөр, түүхий эд материалын төлбөрийг барагдуулах, хуучирч элэгдсэн тоног төхөөрөмжүүдийг нэн даруй шинэчилж сайжруулахад хөрөнгө оруулалт шаарлагатай гэж үзсэн тул ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэнийг танилцуулав.

4. **Атар-Өргөө ХК-ний Санхүү, эдийн засгийн албанаас** 2023 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үзүүлэлтүүдийг танилцуулав.

Тус компани нь 2023 онд 4095 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 19,4 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалт хийж, 1,1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна. Ажилчдын тоог 10% -иар, цалин хөлсийг 15%-иар нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулахад нилээдгүй хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Дэлгэрэнгүй задаргааг мөн хувьцаа эзэмшигчдэд тараах материалаар танилцуулсан болно.

5. **Хурлын дарга Б. Мөнхдалай:** Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүдийн танилцуулга та бүхний өмнө байгаа та бүхэн танилцаад саналаа өгөөрэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин хөлс, үйл ажиллагааны зардлын задаргааг та бүхний өмнө бас хэвлэж тавьсан байгаа, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой цалин хөлс 550000 төгрөг болж нэмэгдснээс бусдаар зардлууд өнгөрсөн жилийнхээрээ байгаа болно.

6. **Хурлын дарга Б. Мөнхдалай:** 2016 онд Атар-Өргөө ХК-ны нийт хувьцааны хяналтын багцыг эзэмшигч байсан 4 гэр бүлийн хувьцаа эзэмшигч нар компаний хөрөнгөөс 4,5 тэрбум төгрөг шамшигдуулсан байсаныг аудитын байгууллагаас илрүүлж, шүүхээр тогтоолгож байсан тухайн нөхцөлд тэдгээр хувьцаа эзэмшигчид нь хууль бусаар Таван богд ХХК-д хувьцаагаа худалдсан байсан. Энэ үйл ажиллагаа шат шатны шүүхээр дамжаар 6 жил үргэлжилж 2022 оны 12 сард өдөр Монгол улсын дээд шүүхээс хяналтынбагц болон түүнээс дээш хэмжээний хувьцааг өөрийн нэр дээр бүртгүүлсэн “Таванбогд инвест” ХХК-ийн эзэмшилд буй хувьцааг саналын эрхгүй гэж үзсэн шийдвэр гарсан. Ийм шийдвэр гарч холбогдох байгууллагуудад мэдэгдсээр байтал байтал хяналтын багцыг бусад хууль бусаар худалдах үйл ажиллагаа явагдсаар байна. Энэхүү үйл ажиллагаа нь өөрөө хууль бусаас гадна компаний тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж, олон сөрөг үр дагавартай байгаа тул Компаний тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу “Таванбогд инвест” ХХК-ийн эзэмшилд буй саналын эрхгүй хувьцааг санал болгох болон бусад хэлбэрээр шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглохоор шийдвэр гаргуулах хүсэлтэй байна.

Дээрх асуудлуудаар хувьцаа эзэмшигчид асуулт хариулт өрнүүлэв.

“Стандарт инвестмент” ХХК-ийг төлөөлж З. Төрболд:

Асуулт: Төлөөлөн удирдах зөвлөл чинь жилд 4 хөн удаа хуралдсан байна. Энэ компаний томоохон асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзэж байна. Хурлынхаа тоог нэмж болохгүй юу.

Хариулт: Туз-ын дарга Б. Мөнхдалай: Хурлын тоог нэмж болноо. Гэхдээ олон хуралдах тусмаа илүү амжилттай ажиллах үндэс болохгүй л дээ, гол гол асуудлуудаа хэлэлцэж шийдвэрлэхээр улиралд нэг удаа хуралддаг байгаа.

Асуулт: Аудитын байгууллага чинь яг зөвшөөрөгдсөн байгууллага мөн үү.

Хариулт: Олон улсын зөвшөөрөл бүхий аудитын компани болно..

О. Баттулгыг төлөөлж оролцож буй О. Баярсайхан:

- Өнгөрсөн 2022 онд 469,8 төгрөгийн ашигтай ажилчихаад яагаад ноогдол ашиг тараагүйг чинь ойлгохгүй байна.

- Хариулт Б. Мөнхдалай: Атар-Өргөө ХК нь хэдийгээр 2022 онд 469,8 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч татварын хуримтлагдсан өр төлбөр, түүхий эд материалын төлбөрийг барагдуулах, хуучирч элэгдсэн тоног төхөөрөмжүүдийг нэн даруй шинэчилж сайжруулахад хөрөнгө оруулалт шаарлагатай гэж үзсэн тул ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн

Хувьцаа эзэмшигч С. Отгонсүрэн: 3 асуулт байна:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийг хангалттай ажиллаагүй гэж үзэж байна. Тиймээс сольж ажиллах нь илүү үр дүнтэй бишүү.

2. Атар-Өргөө ХК-ний гол хувьцаа эзэмшигч Бэрэн групп нь Хөгжлийн банкнаас авсан зээлээсээ Атар-Өргөө ХК-д өгч мөнгө угаасан гэж яригдаад байгаа, энэ үнэн үү.

3. Мөн ногдол ашиг яагаад тараахгүй байгаа вэ.

Хариулт Б. Мөнхдалай:

- Төлөөлөн удирдах зөвлөл цаг үеийн болоод компаний хувьцаа эзэмшигчид маргаантай байгаа өнөөгийн нөхцөлд хангалттай ажиллаж байгаа гэж үзэж байна. Тиймээс солих шаардлагагүй.
- Бэрэн группийн Хөгжлийн банкнаас авсан зээлээс манай Атар-Өргөө ХК нэг ч төгрөг шилжүүлж аваагүй, үүнийг санхүүгийн баримтаараа нотолно. Энэ талаар бид Авилгалтай тэмцэх газар, Татварын ерөнхий газар зэрэг бүхий л холбогдох газруудад тодруулга өгч баримт материалаа шалгуулсан байгаа.
- Ногдол ашиг яагаад тараагаагүй байгаа талаар та бүхэнд түрүүн хангалттай тайлбарласан, энэ жил бид нилээд хуучирч элэгдсэн тоног төхөөрөмжөндөө нилээдгүй хөрөнгө оруулалт хийнэ.

“Таван богд инвестмент” ХХК-ийг төлөөлж Н. Ариунболд: Та бүхний оноодрийн хурлаар хэлэлцүүлж байгаа асуудлуудыг бүгдэд нь би эсрэг санал өгнө. Саналын эрхгүй гээд байгаа хувьцаа эзэмшигчдийн асуудлаар та бүхэнд хэлэхэд Дээд шүүхийн шийдвэр бол зовхон Таван богд инвестмент ХХК-ний хувьцааг саналын эрхгүй гэж үзсэн. Тэрнээс цаашаа худалдаж борлуулж болохгүй гэдэг шийдвэр гараагүй. Энэ талаар танай хуулийнхан ямар зоволгоо өгч байгааг ойлгохгүй байна. Өнөөдрийн энэ ирсэн манай компаниас хувьцаа худалдаж авсан хоёр иргэний хувьцааг саналын эрхгүй гэж үзэж байгаа тооллогын комисстой санал нийлэхгүй байна. Холбогдох газар гомдлоо бид гаргах болно. Энэ маргаанаас болоод танай компаний үйл ажиллагаа цаашид явагдахад хүндрэлтэй болоод байгааг та бүхэн ч гэсэн ойлгох ёстой.

Хувьцаа эзэмшигчид дээрхи асуудлуудыг хэлэлцэж дуусгаад Саналын хуудсыг бөглөж, тооллогын комисст хүлээлгэн өгөв. Тооллогын комисс саналын хуудсыг тоолж дараахь шийдвэр гарсан тухай хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Үүнд:

1.”Атар-Өргөө” ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нийт хүчинтэй 792,216 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 99,96 хувиар зөвшөөрсөн,

2.”Атар-Өргөө” ХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн Аудитын байгууллагын дүгнэлтийг хүчинтэй 792,216 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 99,96 хувиар зөвшөөрсөн,

3.Ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөв онылөлийн шийдвэрийг хүчинтэй 792,216 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 99,96 хувиар зөвшөөрсөн,

4.”Атар-Өргөө” ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг 792,216 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 99.96 хувиар зөвшөөрсөн,

5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход:

А.Ердийн гишүүнээр -Бэрэнбаралын Мөнхдалайг 88059 саналын эрхээр

-Бэрэнбаралын Ганбатыг 88059 саналын эрхээр

-Жамцын Сайнбилэгийг 88059 саналын эрхээр

-Ганзоригийн Энхболдыг 88089 саналын эрхээр

-Ганзоригийн Баттулгийг 88024 саналын эрхээр

-Мөнхдалайн Мөнхтэнгисийг 88024 саналын эрхээр

Б. Хараат бус гишүүнээр –Сүхбаатарын Бямбахорлоог 88059 саналын эрхээр

-Тогоогийн Жигмэддавгыг 88059 саналын эрхээр

-Пүрэвийн Болормааг 88024 саналын эрхээр тус тус сонгосон.

Төлөөлөн удирдах гишүүдийн цалин, дотоод ажлын төсвийг 792,216 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 99,96 хувийн саналаар зөвшөөрсөн.

6. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу хувьцааны хяналтын багцыг худалдахаар санал болгосон хувьцаа эзэмшигчдийн асуудлаар тусгайлан шийдвэр гаргах асуудлыг 792,216 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 99.96 хувиар зөвшөөрснийг танилцуулав.

Хурлын дарга, Б.Мөнхдалай Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн тогтоол гарсаныг танилцуулж, хурлыг хаав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА,

С.БАЯРМАА

ТАНИЛЦСАН: ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ